



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 5/02

Хэрлэн сум

**Ч.Баярцолмонг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43.1, 43.3, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чимэдбатын Баярцолмонг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ч.Баярцолмонгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Дарханбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Ш.Эрдэнэжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Э.Ариунтунгалаг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Д.Энхтуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав

3. Ч.Баярцолмонд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын үндсэн цалинг тооцож, холбогдох бусад нэмэгдлүүдийг хууль, журамд заасны дагуу олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ч.Баярцолмонд үүрэг болгосугай.

5.Ч.Баярцолмонд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.



ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА